



**НИЙСЛЭЛИЙН
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**

Денверийн гудамж-13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190
Утас: (976) 7010 7632
Цахим шуудан: SBD.KHAAA@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2024.01.18 № 13
танай _____-ны № _____-г

Тодруулганы хариу хүргүүлэх тухай

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас зарласан СБДХААА/202412017 дугаартай “Дүүргийн Нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх” бараа нийлүүлэлтийн тендерийн баримт бичгийн ТШЗ-ын 18.3-д тусгасан тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг 2022, 2023 он гэж заасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.”, гэж заасныг үндэслэл болгосон ба энэ хугацаа нь харилцагч санхүүгийн байгууллагад цахимаар хүргүүлэх эцсийн хугацаа учир үүнийг санхүүгийн тайлан гаргах хугацаа гэж ойлгохгүйг анхаарна уу.

ТШЗ-ын 18.6.3-д тусгасан Үндсэн ажилтны НД-7, НД-8 дугаар маягтаар сүүлийн 12 сарын баталгаажуулсан тайлан, “e-mongolia” систем ашиглан ирүүлсэн баримтыг хавсарган ирүүлэх бөгөөд баримт бичгийн хүчинтэй хугацаа дуусаагүй байна. Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн өргүй гэсэн тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй.